

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр

№ 24/01

Улаанбаатар хот

Компанийн үйл ажиллагааны чиглэл нэмэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.22 дахь заалт, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9 дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2.2.31 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) -ийн 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн эцнээ санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг нэмэгдүүлж, цар хүрээг тэлэх зорилгоор “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” үйл ажиллагааг эрхлэн явуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүсэх, холбогдох баримт бичгийг бүрдүүлж өгөх, эдгээртэй холбоотой бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын 2-т заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх” үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгосон тохиолдолд цаашид Компанийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллах “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх бодлого”-ыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
4. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.

